



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2015 оны 11 сарын 23 өдөр

Дугаар 408

Улаанбаатар хот

“Глашиер ассет” ХХК-д хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, 22 дугаар зүйлийн 22.1, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 15 дугаар зүйлийн 15.3.5, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1, 55 дугаар зүйлийн 55.1.4, 2014 оны 08 дугаар тогтоолоор батлагдсан “Хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн болон үйл ажиллагааны журам”-ын 2.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Глашиер ассет” ХХК-д хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг олгосугай.
2. Холбогдох хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлж, хөрөнгө оруулагчдын хууль ёсны эрх ашгийг дээдлэн ажиллахыг “Глашиер ассет” ХХК /Я.Адъяахүү/-д үүрэг болгосугай.
3. Тогтоолыг олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /П.Алтан-Од/-т, Хорооны нэгдсэн бүртгэлд бүртгэхийг Бүртгэл, зөвшөөрлийн газар /Э.Мөнхбаяр/-т, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллахыг Хяналт шалгалтын газар /Б.Оюунцацрал/-т тус тус даалгасугай.

ДАРГА



З.НАРАНТУЯА

001068